

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ КЛИНИКИЙН ТӨВ ГОСПИТАЛЬ 80 ЖИЛД

Л.Баясгалан / ЗХКТГ, анагаах ухааны
дэд доктор , хурандаа /

1921 оны 8-р сарын 15-нд их жанжин Д.Сүхбаатарын санаачилга, шууд оролцоотойгоор цэрэг ардад эмнэлгийн тусlamжийг үнэ төлбөргүй үзүүлэх, "Төвд – Европ эмнэлгийн холимог хороо" - г Ардын засгийн газрын 5-р тогтоолоор анх байгуулснаар Монголдв анх удаа шинжлэх ухааны боловсон эмнэлгийн үндэс суурь тавигдсанаас хойш 80 жил болж байна.

Төр. засаг, цэргийн яамнаас улсыг батлан хамгаалах хүчийг зузаатгах, цэргийн эмнэлгийг бэхжүүлэх талаар шат дараалсан хэд хэдэн чухал арга хэмжээг авч 1924 онд холимог хороог хувьсгалт улаан цэргийн лазарет, 1935 онд хувьсгалт улаан цэргийн лазаретыг госпиталь болгон тус тус өргөтгөж одоогийн ЗХКТГ-ийн байранд шилжүүлэн байрлуулжээ.

1935 – 1936 онуудад цэргийн госпиталийн дэргэдэх ариун цэврийн зааварлагчийн курсыг цэргийн бага эмч бэлтгэх сургууль болгон өргөтгөж 40 гаруй бага эмчийг улсын хэмжээнд анх удаа төгсгөн гаргажээ.

Цэргийн госпиталь нь манай шинжлэх ухааны эмнэлгийн суурийг тавьж, ардын засгийн анхны жилүүдэд ч, дайны цагийн хүнд бэрх жилүүдэд ч, энхийн бүтээн байгуулалтын үед ч армийн нийт бие бүрэлдэхүүний эрүүл мэндийг сахин хамгаалахад гавьяа байгуулж, командлааас өгсөн үүрэг даалгаврыг удаа дараалан нэр төртэй биелүүлсний учир БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн 1955 оны 2-р сарын 25-ны өдрийн 15-р зарлигаар төрийн дээд шагнал "Алтан гадас одон"-гоор шагнагдаж, 1983 онд БНМАУ - ын СнЗ - ийн 330-р тогтоолоор Клиникийн Төв Госпиталь болгосон байна.

Тус эмнэлэгт 80-иад их эмч, үүнээс Монгол Улсын гавьяат эмч 2, эрдмийн зэрэгтэй их эмч 3, мэргэжлийн зэрэгтэй эмч 20-иод ажиллаж байна.

Өнөөдрийн Зэвсэгт Хүчний Клиникийн Төв Госпиталь нь улсын бусад төрөлжсөн клиникийн эмнэлгүүдээс онцлог мэдрэлийн мэс засал, гэмтэл согог, зүрх судасны болон бөөрний чиглэлийн дотрын тасгууд гэх мэт өвөрмөц холимог бүтэц зохион байгуулалттайгаар эмчилгээ үйлчилгээний олон талт үйл ажиллагааг явуулж байна.

Тус эмнэлгийн бүтцэнд өнөөдөр хордлогын яаралтай тусlamжийн үндэсний төв багтаж үйл ажиллагааг явуулж улсын хэмжээний асуудлыг шийдэж байна.

Мөн улс оронд байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн олныг хамарсан осол, аварын үед аврахуйн анагаах ухааны чиглэлээр тус эмнэлгийг давуутай хөгжүүлэх бодлого баримталж ирснээр өнөөдөр иргэний хамгаалалтын тусгай үүрэг бүхий томилгоот нарийн мэргэжлийн бүлгүүд бэлэн байдалд байдаг юмаа. Одоогоор улсын хэмжээнд зөвхөн тус эмнэлэгт барокамерын эмчилгээг явуулж байна.

Алдар гавьяаны арвин баялаг түүхтэй ЗХКТГ-ийн хамт олон түүхт 80 жилийнхээ ойг угтан цэргийн эмнэлгийн өөрчлөлт шинэчлэлтийн чиг баримтлалыг хэрэгжүүлэн үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийг найдвартай хамгаалахын төлөө зорилт тавин ажиллаж байгаа цаг мөчид "Онош" сэтгүүлийн энэ дугаарыг тус эмнэлгийн эмч, эрдэмтэдийн бэлтгэсэн материалыг хэвлэхэд зориулж байгаад тус сэтгүүлийн редакцийн хамт олонд халуун талархал илэрхийлж байна.

Номын арвин цагаан буян дэлгэрэх болготугай.

Онош - Diagnos - Diagnosis-Диагноз

**Монголын гастроэнтеролог эмч нарын
эрдэм шинжилгээ - практикийн улирал тутмын сэтгүүл**

Сэтгүүлийн цэц

С.Бадамжав /эрхлэгч/

Б.Дагвадорж, А.К.Жангабылов, Г.Энхдолгор,

Т.Алтанцэцэг, Б.Ганбаатар, Г.Зулхүү,

Г.Сүхбат, Ц.Сарантуяа,

Сэтгүүлийн зөвлөл

Д.Гончигсүрэн, Д.Энхбаяр,

Н.Бира, Д.Цэрэндагва, Н.Туул,

С.Гантуяа, Ш.Оюунгэрэл

Дугаар № 2 (10)

Улиралд 1 удаа

/Захиалгын үнэ 1000 төг, худалдаалах үнэ 2000/

Хууль зүйн яамны бүртгэл № 175

Сэтгүүлийн эхийг

бэлтгэсэн Б.Тэгшжаргал

"Урлах эрдэм"-д хэвлэв.

Цаасны хэмжээ 60x80, 1/8

Индекс

14175

Сэтгүүлийн зөвлөл:

Хаяг: Улаанбаатар-210648.

Холбооны газар - 48

210648

Шуудангийн хайрцаг. 67,

„ОНОШ „, сэтгүүл

E -Mail: Badamjav @ mol. mn

Утас: 99176272